

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ”
ХААЛТТАЙ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “АСН” ХХК нь / цаашид компани гэх / Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банкны харилцах данстай, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй, тусгайлан эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх эдэлж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг, шүүх, арбитрын өмнө өөрийн нэрийн өмнөөс оролцдог хуулийн этгээд байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагддаг, хаалттай хувьцаат компани байна.
- 1.2. Компанийн оноосон нэр нь “АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК байх ба англиар "ARD FINANCIAL GROUP" Joint Stock Company буюу товчилсон байдлаар АСН ХК, англиар AFG JSC гэж нэрлэнэ.
- 1.3. Компанийн бэлгэдэл тэмдэг нь  гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь санхүүгийн нэгдэл гэж бичсэн байна.
- 1.4. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.
- 1.5. Компанийн албан ёсны хаяг нь: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу/14200/, Б.Алтангэрэлийн гудамж 5, III/Хаяг 210646/ УБ-46, Сити центр барилгын-403 тоот

ХОЁР. КОМПАНИЙН ЗОРИЛГО
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1. Компани нь дараах зорилгыг ханган ажиллана. Үүнд:
Бид Монгол Улсын хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани байхыг зорьж ажиллах бөгөөд Хөрөнгө оруулагчдын санхүүгийн өгөөжийг зохистой түвшинд байлгахын тулд ашиг болон эрсдлийн хэтийн харьцааг тэнцвэртэй барих бодлогыг чиглэл болгон ажиллана.
- 2.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:
 - 2.2.1. Хөрөнгө оруулалт;
 - 2.2.2. Бизнесийн зөвлөгөө;
 - 2.2.3. Монгол Улсын хууль тогтоомжид хориглоогүй аливаа бусад төрлийн үйл ажиллагааг явуулна.
- 2.3. Компани нь тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий байгууллагаас зохих журмын дагуу холбогдох тусгай тусгай зөвшөөрөл авч бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Компани нь Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.
- 3.2 Компани нь өөрийн үйл ажиллагаагаа зөвхөн бие даасан байдлаар эсвэл дотоод, гадаадын хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 3.3 Компани үйл ажиллагаагаа Монгол Улсын Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд явуулна.
- 3.4 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох Хөрөнгө оруулалт нь ТУЗ-ийн удирдлагын хяналтан дор явагдах бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал шийдвэрлэн хэрэгжүүлнэ.
- 3.5 Компани нь өөрийн нэрийн барааны тэмдэг, эмблем, бэлэг тэмдэгтэй албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга, тэмдэг хэрэглэнэ. Бэлэгдэл барааны тэмдгийг Оюуны өмчийн газар бүртгүүлж тэдгээрийн хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.
- 3.6 Компани нь үйл ажиллагааны чиглэлээс хамаарч охин болон хараат компани, салбар төлөөлөгчийн газар байгуулж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
- 3.7 Компани үндсэн үйл ажиллагаандаа мэргэжилдээ туршлагатай, ур чадвартай хүмүүсийг хөдөлмөрийн хуулинд нийцүүлэн гэрээгээр авч ажиллуулан тэдний цалин урамшил, ажиллах нөхцлийг нь тогтооно.
- 3.8 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.
- 3.9 Компани нь өөрийн бизнес үйл ажиллагаатай холбоотой зүйлийг хуулийн дагуу нууцалж болно.
- 3.10 Компани нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахтай холбогдуулан сан байгуулж болно.
- 3.11 Компани нь хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг хөтөлж эсхүл үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ХАРИУЦЛАГА

- 4.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
- 4.2. Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчид нь компанийн хариуцлагыг өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хүлээнэ.
- 4.3. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.
- 4.4. Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, дэд захирал, хэлтэс, албаны дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанид учруулсан хохирлыг хариуцна.

- 4.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 5.1. Компанийн энгийн хувьцааг зохих журмын дагуу худалдан авсан эсхүл эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
- 5.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь гэрээ, дүрэм журмын заалтыг хэлбэрэлтгүй сахиж, компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлэх, компанийн нууцад хамааралтай бүхий л зүйлийг чандлан хадгалж, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол гэрээгээр хүлээсэн үүрэг, хөдөлмөрийн хуулийг чанд биелүүлэх, компанийн үнэт цаас эзэмшиж байгаа этгээд нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар компанид болон үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад зохих журмын дагуу мэдэгдэх зэрэг үүрэг хүлээнэ.
- 5.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах, компанийн ажил хэргийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзолшгүй үйлдэл хийхийг хориглоно.
- 5.4. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.
- 5.4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
- 5.4.2. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;
- 5.4.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- 5.4.4. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах;
- 5.4.5. Дор дурьдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Үүнд:
- 5.4.5.1. Нийлэх, нэгдэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах болсон бол;
- 5.4.5.2. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, компанийн урьд

- гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;
- 5.4.5.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;
- 5.4.5.4. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- 5.4.6. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид нь ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарах асуудлаар саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд санал гаргах;
- 5.4.7. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;
- 5.4.8. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
- 5.4.9. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

ЗУРГАА. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА БУСАД ҮНЭТ ЦААС, ТҮҮНИЙГ ГАРГАХ, ХУДАЛДАХ БОЛОН ЭРГҮҮЛЭН АВАХ

- 6.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагдах бөгөөд компанийн нийт зарласан энгийн хувьцааны үнэ нь 2,275,270,000 (хоёр тэрбум хоёр зуун далан таван сая хоёр зуун далан мянга) төгрөг байх бөгөөд 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 22,752,700 (хорин хоёр сая долоон зуун тавин хоёр мянга долоон зуу) ширхэг хувьцаа байна. Хувьцаа эзэмшигчид энэхүү дүрэмд хавсаргасан Хувьцаа Эзэмшигчдийн бүтцэд тусгасан байдлаар хувьцаа эзэмшинэ.
- 6.2. Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно:
- 6.2.1. Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;
- 6.2.2. Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох;
- 6.2.3. Өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх.
- 6.3. Компани нь энгийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргаж болно.

- 6.4. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт үнэт цаас гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах үнэт цаасны төрөл, тоо нэрлэсэн үнэ, үнийн дүн, гаргах хугацаа нөхцөл зэргийг заасан байна.
- 6.5. Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, шинэ бизнес эрхлэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, гүйлгээнд оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 6.6. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ шийдвэрлэнэ.
- 6.7. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 2 жил хүртэлх хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Шийдвэрт өрийн бичиг гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэн төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.
- 6.8. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 2-оос дээш жилийн хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шийдвэрт энэ дүрмийн 6.4-т заасан мэдээллийг мөн адил тусгана.
- 6.9. Компанийн тодорхой тооны энгийн хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдаж авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно. Опционоор худалдаж авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах тухай шийдвэрийг ТУЗ, түүнээс их бол хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Шийдвэрт опцион гаргах болсон үндэслэл, гаргах опционы тоо, опцион эзэмшигчийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдан авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционы үнэ зэргийг заасан байна.
- 6.10. Хувьцаа бусад үнэт цаасны нийт үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны үндэслэн ТУЗ тогтооно.
- 6.11. Компаниас шинээр гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлбэрээр хийхийг сонирхогч бус ТУЗ-ийн саналаар тогтооно. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын санал дүгнэлтийг үндэслэж болно.
- 6.12. ТУЗ-ийн шийдвэрээр компани нь өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдаж авч болно. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна. Худалдан авсан өөрийн хувьцааг халаасны хувьцаа гэнэ.
- 6.13. Компани нь дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргаж болно.
 - 6.13.1. хуульд заасан үүргийнхээ дагуу эргүүлэн авах энгийн хувьцаа бол;

- 6.13.2. үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байвал;
- 6.13.3. компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их бол.
- 6.14. Компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.
- 6.15. Компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээд буюу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид ХЭХ гэх) байна.
- 7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
- 7.3. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) нь “Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам”-ыг баталж мөрдүүлнэ.
- 7.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор ТУЗ-өөс зарлаж, хуралдуулах бөгөөд Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гаргаж хуралдуулна.
- 7.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-өөс шийдвэрлэж хуралдуулна.
- 7.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэхь хэсэгт заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 7.7. 7.4 дүгээр зүйлийн дагуу гаргасан шийдвэрт тусгасан хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ХЭХ-ыг даргалах боломжгүй болсон тохиолдолд компанийн ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдана.
- 7.8. Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход Компанийн тухай хуулийн 71.5, 72.1.3, 72.2, 77.1-т тус тус заасны дагуу санал хураалтын кумулятив аргаар явуулна.
- 7.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.10. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Компаниас баталсан журмын дагуу явуулна.
- 7.11. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 68 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуулийн 63-64 дүгээр зүйлд зааснаар бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг үндэслэн өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулж болно.

- 7.12. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.
- 7.13. Компанийн саналын эрхтэй хувьцааны олонх хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуудах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэж ТУЗ-ийн дарга, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаас хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүй болно.
- 7.14. Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.5-д заасан журмын дагуу ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Өмнөх хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.
- 7.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.
- 7.16. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.
- 7.17. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.
- 7.18. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга баталгаажуулан гарын үсэг зурна.

НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

- 8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь Компанийн тухай хууль, энэ дүрмээр хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 8.1.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- 8.1.2. Хувьцаа эзэмшигчийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;
- 8.1.3. Компанийн тухай хууль болон хувьцаа эзэмшигчийн хурлаас эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.
- 8.2. Компанийн ТУЗ нь 9 болон түүнээс дээш гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгон ажиллуулж болно.
- 8.3. Гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд ТУЗ-өөс түүний оронд өөр хүнийг түр томилно.
- 8.4. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн санал хураалтын олонхийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн үүрэг гүйцэтгэнэ.

ТУЗ-ийн дарга нь:

- 8.4.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих үүрэгтэй.
- 8.4.2. ТУЗ-ийн дарга үйл ажиллагааны журмаар тогтоосон өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах болон компанийн эрх ашгийг төлөөлөх, компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаагаа явуулах эрхтэй байна.
- 8.5. ТУЗ-ийн хурал хуралдуулах хугацааг ТУЗ-ийн дотоод журмаар тогтооно. ТУЗ нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална.
- 8.6. ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор хороодтой байна. Эдгээр хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 8.7. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн санаачлага, шаардлагаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 8.8. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 8.9. ТУЗ-ийн хэлэлцэж шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр эсхүл эчнээ санал хураалтын дүнгүйгээр ТУЗ-ийн дарга нь дангаараа эсхүл аль нэг гишүүн болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу төлөөлөн удирдах зөвлөлөөр сонгогдоогүй тохиолдолд ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.
- 8.10. ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хурал даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
- 8.11. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

ЕС. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 9.1. Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх) нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 9.2. Төлөөлөн удирдах зөвлөл зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.
- 9.3. Гүйцэтгэх захирлын төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 9.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 9.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө.

- 9.6. Гүйцэтгэх захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар авч хянан хэлэлцэнэ.
- 9.7. ТУЗ гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох, хязгаарлах эрхийг хэзээ ч гаргаж болно.

АРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРТГЭЛ ТАЙЛАН НОГДОЛ, АШИГ ХУВААРИЛАХ

- 10.1. Компани нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу гаргаж баталгаажуулах бөгөөд тайланг хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.
- 10.2. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ий өдрөөр дуусгавар болно.
- 10.3. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан хариуцна.
- 10.4. Санхүүгийн тайлан нь Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.
- 10.5. Ногдол ашиг хуваарилалтын шийдвэрийг ТУЗ гаргана. ТУЗ-ийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах “бүртгэлийн өдөр” болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 10.6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ашиг хуваарилна. Ногдол ашгийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ

- 11.1. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- 11.2. ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар аудитын хороо нь 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатай сонгогдоно.
- 11.3. Аудитын хорооны бүрэн эрх, чиг үүрэг, гишүүдэд тавих шаардлага зэргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулах бөгөөд бусад зүйлийг аудитын хорооноос баталсан дотоод журмаар зохицуулна.
- 11.4. Аудитын хороо нь хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй.
- 11.4. Аудитын хороо нь ТУЗ-д ажлаа тайлагнана.
- 11.5. Аудитын хороо нь аудитын тухай хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг ТУЗ-өөр батлуулна.

- 11.6. Гэрээнд компанийн болон аудиторын эрх, үүрэг хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
- 11.7. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
- 11.8. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 11.9. Дараах этгээдийг компанийн аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
 - 11.9.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрт нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
 - 11.9.2. компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эзэмшдэг бол;
 - 11.9.3. компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.
- 11.10. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д заасан компанийн бичиг баримтыг Компани нь хяналт шалгалт, лавлагаа, түүх, архивын зорилгоор холбогдох хуульд зааснаар хадгална.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

- 12.1. Компанийг ХЭХ-ын шийдвэрээр буюу Компанийн хуульд заасан бусад үндэслэлээр өөрчлөн байгуулах (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөн зохион байгуулах) замаар өөрчлөн байгуулж болно.
- 12.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
- 12.3. ХЭХ-ын шийдвэрээр компанийг татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Татан буулгах комисс, хэрэв шүүхийн шийдвэрээр татан буугдаж байгаа бол шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- 12.4. Дор дурьдсан үндэслэлээр шүүх компанийг татан буулгана:
 - 12.4.1. Компани дампуурсан;
 - 12.4.2. Нэг ч гишүүн үлдээгүй;
 - 12.4.3. Хуульд заасан бусад үндэслэл.
- 12.5. Компанийг татан буулгах тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангасны дараа үлдсэн хөрөнгө (үүний дотор компанийн эд хөрөнгийг борлуулсны орлого мөн орно)-ийг Компанийн хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.
- 12.6. Компанийг бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассанаар татан буулгасанд тооцно.

АРВАН ГУРАВ. БУСАД НӨХИЦЛҮҮД

- 13.1. Энэхүү дүрэмд гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлын дийлэнх олонхийн шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 13.2. Энэхүү дүрэм болон холбогдох журамд шууд заагаагүй аливаа асуудлыг тухайн үед нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын хууль болон эрх зүйн бусад актаар зохицуулна.
- 13.3. Энэхүү дүрэм нь УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж Компани татан буугдах буюу өөрчлөн байгуулагдах хүртэл хугацаагүй үйлчилнэ.
- 13.4. Энэхүү дүрэм нь Монгол хэл дээр 3 хувь үйлдэж, УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт, татварын албанд тус тус нэг нэг хувийг, компанид нэг хувийг хадгална.

2014 оны 12 сарын 3

Ард Санхүүгийн Нэгдэл ХК

Хувьцаа эзэмшигчдийн
2015 оны ...дугаар сарын-ний өдрийн
..... тоот тогтоолоор батлав

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны тоо	ХНХөрөнгө	Хувь эзэмшил
1	ЮУ БИ АЙ ЖИ ХХК	1,907,059	190,705,900	11.09%
2	ИНТЕРГРУПП ИНТЕРНЭЙШНЛ ХХК	1,871,276	187,127,607	10.88%
3	АПОЛЛА ВЕНТУРС ХХК	1,690,000	169,000,000	9.83%
4	ЛУНА ЭНД ЛУНА ХХК	1,373,801	137,380,100	7.99%
5	VENTURSONE BV	1,304,043	130,404,300	7.58%
6	ЧУЛУУН ГАНХУЯГ	1,290,000	129,000,000	7.50%
7	МАК ХХК	873,000	87,300,000	5.08%
8	БАЯРТОГТОХ НЭМЭХБААТАР	507,834	50,783,400	2.95%
10	BRUNO RASCHLE	461,016	46,101,591	2.68%
9	ХУЛДОРЖ БҮРЭН-ЭРДЭНЭ	457,300	45,730,000	2.66%
11	ЛХАГВАСҮРЭН СОРОНЗОНБОЛД	453,210	45,321,000	2.64%
12	СЭДБАЗАР ГЭРЭЛТУЯА	452,000	45,200,000	2.63%
13	ГАЛНЯМ УЯНГА	431,589	43,158,900	2.51%
14	МӨНХ-ОЧИР СЭРГЭЛЭН	350,794	35,079,400	2.04%
15	ДҮГЭРСҮРЭН БАТ-ОЧИР	313,650	31,365,000	1.82%
16	МЯГМАРСҮРЭН ЗОЛЖАРГАЛ	300,000	30,000,000	1.74%
17	ЧУЛУУН ГАНЗОРИГ	229,940	22,994,000	1.34%
18	БАЯРЖАРГАЛ ДЭЛГЭРЖАРГАЛ	221,960	22,196,000	1.29%
19	RONOS LIMITED	305,697	30,569,700	1.78%
20	БАРАМСАЙ ГАНБАТ	191,387	19,138,700	1.11%
21	ДОРЖГОТОВ ЭРДЭНЭЧИМЭГ	152,830	15,283,000	0.89%
22	ЯДАМСҮРЭН НАЦАГДОРЖ	141,332	14,133,200	0.82%
23	НИКОЛЬ БОРОХОВ	125,277	12,527,733	0.73%
24	ШАРАВДОРЖ ЧИНЦЭЦЭГ	95,910	9,591,000	0.56%
25	ГАНИБАЛ АМАРТҮВШИН	85,000	8,500,000	0.49%
26	АРЪЯАСҮРЭН БАТБОЛД	104,331	10,433,100	0.61%
27	ГАЛБАДРАХ ЦОГБАДРАХ	73,390	7,339,000	0.43%
28	ФАЙЗУЛЛА САЙДОВ	70,000	7,000,000	0.41%
29	ЮНДЭН ГЭРЭЛМАА	69,100	6,910,000	0.40%
30	ЭРДЭНЭСҮХ БҮРТГЭЛЖИН	52,860	5,286,000	0.31%
31	ЖҮРМЭД ЗАНАА	48,500	4,850,000	0.28%
32	МАРКСЕН ФИЛИПП	43,000	4,300,000	0.25%
33	ЖАРГАЛСАЙХАН МӨНХСАЙХАН	40,000	4,000,000	0.23%
34	ЖАМБАЖАВ ЭНХТУНСАГ	39,790	3,979,000	0.23%
35	ЗАГ ХХК	33,000	3,300,000	0.19%
36	ЖИГЖИДСҮРЭН ОДАГАРДУЛАМ	31,400	3,140,000	0.18%
37	ХИШИГСҮРЭН ГАНЖОЛОО	29,020	2,902,000	0.17%
38	МОНЕТ КАПИТАЛ ХХК	28,868	2,886,800	0.17%
39	ЧУЛУУНБАТ ТУЯАЦЭЦЭГ	22,120	2,212,000	0.13%
40	БАЛДАН-ЁНДОН ЯНЖИНДУЛАМ	26,620	2,662,000	0.15%
41	ЧУЛУУН ЦЭЦГЭЭ	24,540	2,454,000	0.14%
42	НЭРГҮЙ БАТЖАРГАЛ	22,550	2,255,000	0.13%
43	БАТ-ДОРЖ ЦЭЦЭГМАА	20,450	2,045,000	0.12%
44	ДАШНЯМ АМАРБАЯСГАЛАН	22,000	2,200,000	0.13%
45	ГАНБОЛД БОЛОР-ЭРДЭНЭ	19,730	1,973,000	0.11%
46	ЖАМБАЛДОРЖ ЭНХБААТАР	19,560	1,956,000	0.11%
47	ТРАСКО ХХК	17,930	1,793,000	0.10%
48	ДОРЖСҮРЭН АРИУНБОЛД	16,880	1,688,000	0.10%
49	ЗУЛПАЙ БАТЫРБЕК	6,720	672,000	0.04%
50	ХОРОЛ АМАРАА	14,730	1,473,000	0.09%

Хувьцаа эзэмшигчдийн
2015 оны ...дугаар сарын-ний өдрийн
..... тоот тогтоолоор батлав

51	ДҮГЭРЭЭ БОЛДБААТАР	13,770	1,377,000	0.08%
52	СЭРЭЭТЭР ЭНХЦЭЦЭГ	13,000	1,300,000	0.08%
53	ДУЛАМ ТУЛГА	13,000	1,300,000	0.08%
54	ХОНЬХҮҮ ОЮУНБАЯР	12,870	1,287,000	0.07%
55	ХАДАНХЯСАА ЦЭНГЭЛБАЯР	12,060	1,206,000	0.07%
56	ЮРА БАТБААТАР	11,870	1,187,000	0.07%
57	ЛУТ-ОЧИР ГАНТУЯА	11,810	1,181,000	0.07%
58	ЭРДЭНЭБИЛЭГ МӨНХТУУ	11,110	1,111,000	0.06%
59	ДОРЖ ТУНГАЛАГТӨГС	10,810	1,081,000	0.06%
60	ДОРЖБАТ АЛИМАА	10,270	1,027,000	0.06%
61	КАКЕША НУРБЕК	10,100	1,010,000	0.06%
62	ЦЭНДСҮРЭН ХАЛИУН	10,000	1,000,000	0.06%
63	ГЭНДЭНПИЛ ЧИНЗОРИГ	10,000	1,000,000	0.06%
64	ГАНСҮХ ГАН-ЭРДЭНЭ	10,000	1,000,000	0.06%
65	ГАН-ЭРДЭНЭ ХУЛАН	10,000	1,000,000	0.06%
66	СҮХБААТАР МӨНХБОЛД	9,820	982,000	0.06%
67	ДАВАА БОЛОРМАА	9,490	949,000	0.06%
68	ЧОЙГҮНСЭН ЦЭРЭНХАНД	9,210	921,000	0.05%
69	НАМСРАЙ ТҮМЭНЖАРГАЛ	9,190	919,000	0.05%
70	ДАВААЦЭРЭН ТӨГСБАЯР	9,091	909,100	0.05%
71	ПҮРЭВЖАРГАЛ БАТБАЯР	9,000	900,000	0.05%
72	БЯРААЗАНА ЭНХНАСАН	8,930	893,000	0.05%
73	ГАНХУЯГ ГАНЧИМЭГ	8,700	870,000	0.05%
74	БАНЗРАГЧ БОЛОРМАА	8,440	844,000	0.05%
75	ДАМЧАА ЧИМЭДЦЭРЭН	7,640	764,000	0.04%
76	ТӨМӨРБААТАР БАЗАРРАГЧАА	7,520	752,000	0.04%
77	ГҮРРАГЧАА СҮХБААТАР	7,220	722,000	0.04%
78	ДАВААЖАВ ЭНХТОГТОХ	7,030	703,000	0.04%
79	ЗОГСООСҮРЭН ӨЛЗИЙБАЯР	6,870	687,000	0.04%
80	ЦЭВЭЭНЖАВ НАРАНЗАЯА	6,840	684,000	0.04%
81	БАЛТСҮХ ЭРХЭМСАЙХАН	6,760	676,000	0.04%
82	ДАВААЖАМЦАН МӨНХЗУЛ	6,680	668,000	0.04%
83	ДАШЗЭВЭГ ОЧБУЛАГ	6,660	666,000	0.04%
84	ЦОГТСАЙХАН ЧАНДМАНЬ	6,580	658,000	0.04%
85	СЭРСЭН НЯМСҮРЭН	6,240	624,000	0.04%
86	ОЮУНБААТАР УНДРАА	6,100	610,000	0.04%
87	БАТЖАРГАЛ БАТНСАН	6,080	608,000	0.04%
88	НАТАР ГАНХҮҮ	6,000	600,000	0.03%
89	М СИ ЭС ХОЛДИНГ ХХК	6,000	600,000	0.03%
90	ЭРДЭНЭБИЛЭГ ЭЛБЭГЗАЯА	5,750	575,000	0.03%
91	ГАНБОЛД ГАНЧУЛУУН	5,680	568,000	0.03%
92	БААРАВ ДАРИЙМАА	5,660	566,000	0.03%
93	ЧИНЧУЛУУН ЭНХТУУЛ	5,640	564,000	0.03%
94	ГАЛСАНЧОЙДОН ОТГОНХАНД	5,580	558,000	0.03%
95	АЛГАА САЙНБИЛЭГ	5,500	550,000	0.03%
96	ЛУВСАНЦЭРЭН ӨЛЗИЙЖАРГАЛ	5,460	546,000	0.03%
97	Чулуунбаатар Хандаа	5,458	545,800	0.03%
98	БАЯРАА АЛТАНГОО	5,220	522,000	0.03%
99	Г.ӨСӨХБАЯР	5,040	504,000	0.03%
100	РЭНЦЭНДАГВА ДАГВА	5,000	500,000	0.03%
101	БАЯНСАН УЛАМБАЯР	5,000	500,000	0.03%
102	ЛХАВГАСҮРЭН ЖАВЗМАА	5,000	500,000	0.03%
103	ТОГТОХБАЯР БАТЦЭНГЭЛ	2,929	292,900	0.02%
104	ЛХАГВА ГАНЧИМЭГ	4,500	450,000	0.03%
105	БАНЗРАГЧ ДЭЛГЭРМАА	4,500	450,000	0.03%
106	ОЙДОВСАМБУУ БААСАН	4,280	428,000	0.02%
107	ДАМБИЙЖАВ ТЭРБААТАР	4,250	425,000	0.02%

Хувьцаа эзэмшигчдийн
2015 оны ...дугаар сарын-ний өдрийн
..... тоот тогтоолоор батлав

108	ТӨРБАТ СЭЛЭНГЭ	4,120	412,000	0.02%
109	ПАЛАМ ТУЯА	4,120	412,000	0.02%
110	Ч.ДЭЛГЭРМАА	4,110	411,000	0.02%
111	ЗААНХҮҮ УЯНГА	4,040	404,000	0.02%
112	БЯЦХАН МЯДАГНЯМАА	3,960	396,000	0.02%
113	ГАНТӨМӨР ЗУЛЦЭЦЭГ	3,930	393,000	0.02%
114	АЮУРЗАНА ГАЛААЗАГРАА	3,840	384,000	0.02%
115	АЛТАНХУЯГ УРТНАСАН	3,730	373,000	0.02%
116	ТҮДЭВДАГВА ЭРДЭНЭБАТ	3,690	369,000	0.02%
117	ДАШПИЛ ОРОЛЗОД	3,630	363,000	0.02%
118	ПҮРЭВДОРЖ ТӨМӨР-ОЧИР	3,350	335,000	0.02%
119	ТӨМӨРБААТАР МӨНХТӨР	3,240	324,000	0.02%
120	ЖУДАА ЖАВЗАНХАНД	3,170	317,000	0.02%
121	ГУЛИСЛАМ БОТАГОЗ	3,120	312,000	0.02%
122	ЦЭРЭГДАШ ЭНХЦЭЦЭГ	3,000	300,000	0.02%
123	НАРАНГЭРЭЛ ЦЭГЦ	3,000	300,000	0.02%
124	ДАМБАДАРЖАА ЖАРГАЛСАЙХАН	3,000	300,000	0.02%
125	ЛХАВГАДОРЖ ГАНТУЯА	2,990	299,000	0.02%
126	ГОМБОДОРЖ ГАНЧИМЭГ	2,910	291,000	0.02%
127	СҮХБААТАР ЦЭЦГЭЭ	2,800	280,000	0.02%
128	ОЧИРХУЯГ ОЮУНСҮРЭН	2,600	260,000	0.02%
129	ДЭЛГЭР ДАВААДОРЖ	2,580	258,000	0.02%
130	БАДРАХ СЭРГЭЛЭНЧИМЭГ	2,550	255,000	0.01%
131	ОЮУНМАА ГҮНЖЛХАМ	2,500	250,000	0.01%
132	ДОРЖЛХАГВА ЦАЦРАЛ	2,480	248,000	0.01%
133	УЛАМСАЙХАН САРУУЛТӨГС	2,470	247,000	0.01%
134	СЭРЭЭТЭР БАТТОГТОХ	2,440	244,000	0.01%
135	АМГААБАЗАР ЦЭРМАА	2,400	240,000	0.01%
136	САНЖИД ОДОНЧИМЭГ	2,370	237,000	0.01%
137	БЯМБА БАЛЖМАА	2,330	233,000	0.01%
138	ГАНБОЛД ХАШ-ЭРДЭНЭ	2,300	230,000	0.01%
139	МОЛОМ ОТГОНБАЯР	2,280	228,000	0.01%
140	СҮХБААТАР БАТЧИМЭГ	2,260	226,000	0.01%
141	ДОРЖМЭД СОЁЛЦЭЦЭГ	2,260	226,000	0.01%
142	ИВАН ЧУЛУУНБАДРАХ	2,240	224,000	0.01%
143	ДАВААДОРЖ ӨЛЗИЙДЭЛГЭР	2,200	220,000	0.01%
144	БАЯРСАЙХАН ОДМАА	2,180	218,000	0.01%
145	ХҮРЛЭЭ БАТЦОГ	2,170	217,000	0.01%
146	БАТТӨМӨР МӨНХТОГОО	2,140	214,000	0.01%
147	ХАЛТАР БИЛЭГТ	2,140	214,000	0.01%
148	ЦЭНДСҮРЭН ЦЭВЭЭСҮРЭН	2,100	210,000	0.01%
149	ЛХАГВА ЭРДЭНЭДАЛАЙ	2,040	204,000	0.01%
150	МИШИГ ОЮУНЧИМЭГ	2,020	202,000	0.01%
151	ПОЛИО МАЙДАР	1,960	196,000	0.01%
152	ПҮРЭВЖАВ САРАНБАТ	1,950	195,000	0.01%
153	ЦЭРЭНПУНЦАГ ОЮУНБАТ	1,920	192,000	0.01%
154	ЭРДЭНЭЧУЛУУН ГАНБААТАР	1,910	191,000	0.01%
155	МААМУУ ПҮРЭВХҮҮ	1,910	191,000	0.01%
156	ЖАРГАЛСАЙХАН БАЙГАЛМАА	1,850	185,000	0.01%
157	САНДАГДОРЖ СОДБАЯР	1,820	182,000	0.01%
158	ОЮУНГЭРЭЛ АДЪЯА	1,810	181,000	0.01%
159	ТОЛЯ БАТБАЯР	1,800	180,000	0.01%
160	ЭНХБАЯР МӨНХЗАЯА	1,800	180,000	0.01%
161	ЦЭВЭГДОРЖ МӨНХБУЙР	1,790	179,000	0.01%
162	ПҮРЭВДАГВА ЦЭРЭНДУЛАМ	1,760	176,000	0.01%
163	МЯДАГДОРЖ СҮНЖИДМАА	1,760	176,000	0.01%
164	ЭРДЭНЭБАТ БЯМБАЦЭРЭН	1,700	170,000	0.01%

Хувьцаа эзэмшигчдийн
2015 оны ...дугаар сарын-ний өдрийн
..... тоот тогтоолоор батлав

165	ЦЭРЭНДОРЖ АЛТАНСҮХ	1,700	170,000	0.01%
166	ЮНЭРЭН НЭРГҮЙ	1,690	169,000	0.01%
167	ЛХАГВАЖАВ ШИРЧМАА	1,690	169,000	0.01%
168	ДОНСОГ АНГАРАГ	1,670	167,000	0.01%
169	ЖАМСРАНЖАВ МЯГМАРЖАВ	1,600	160,000	0.01%
170	ГАНБААТАР МӨНХГЭРЭЛ	1,590	159,000	0.01%
171	ЦЭНДСҮРЭН МӨНГӨНЦЭЦЭГ	1,570	157,000	0.01%
172	МЯГМАР АЛТАНСҮХ	1,550	155,000	0.01%
173	ДЭЛГЭРБЯМБА АДАРСҮРЭН	1,540	154,000	0.01%
174	ГАНБОЛД ХАНГАЙ	1,530	153,000	0.01%
175	ГАНБОЛД ОРГИЛБОЛД	1,520	152,000	0.01%
176	БАЯНМӨНХ БАЯРМАА	1,510	151,000	0.01%
177	БАТЗОРИГ ОДОНЧИМЭГ	1,510	151,000	0.01%
178	ПҮРЭВДАГВА ПҮРЭВЦЭНД	1,510	151,000	0.01%
179	ОЮУНЧИМЭГ БАТБАЯР	1,510	151,000	0.01%
180	ИТГЭЛ БАДНААГАРАВ	1,480	148,000	0.01%
181	АНДРЕЙ МӨНХ-ЭРДЭНЭ	1,470	147,000	0.01%
182	ГҮНСЭНХОРЛОО СҮРЭНХОРЛОО	1,460	146,000	0.01%
183	ШАРАВДОРЖ МЯНГАНБАЯР	1,430	143,000	0.01%
184	ЛХАГВА ГАНТУЛГА	1,420	142,000	0.01%
185	БУЛГАН ОЮУНЦЭЦЭГ	1,400	140,000	0.01%
186	ЛХАГВАЖАВ БАТБАЯР	1,390	139,000	0.01%
187	ДАРЬЗАВ ГЭРЭЛТУЯА	1,390	139,000	0.01%
188	МАЙЛУУ МИШИГДОРЖ	1,370	137,000	0.01%
189	МЯНГАНБААТАР ТУЯА	1,370	137,000	0.01%
190	НЯМСҮРЭН САНСАРТУЯА	1,340	134,000	0.01%
191	САЙНБАЯР БАЯРСҮРЭН	1,340	134,000	0.01%
192	БАЯРСАЙХАН МӨНХ-ОД	1,330	133,000	0.01%
193	ЖАМЪЯНЖАМЦ НЯМЛХАГВА	1,310	131,000	0.01%
194	НАРМАНДАХ БОЛДХҮҮ	1,310	131,000	0.01%
195	БОЛД ХҮРЭЛБААТАР	1,310	131,000	0.01%
196	БЭГЗ ПҮРЭВСҮРЭН	1,290	129,000	0.01%
197	СОСОРБАРАМ АЛТАННАРАН	1,290	129,000	0.01%
198	ДОЛЖИНСҮРЭН УНДАРМАА	1,260	126,000	0.01%
199	СЭРЭЭТЭР ЛАНТУУСҮХ	1,240	124,000	0.01%
200	ТҮМЭНЖАРГАЛ БУЯНГЭРЭЛ	1,230	123,000	0.01%
201	ТОГМИД ТҮМЭНБАЯР	1,230	123,000	0.01%
202	ГАЛБАДРАХ СҮХБАТ	1,220	122,000	0.01%
203	БАЯНЖАРГАЛ АРИУНЗАЯА	1,210	121,000	0.01%
204	АДЪЯА БААСАНХҮҮ	1,200	120,000	0.01%
205	ГОНЧИГ ТӨРБАТ	1,190	119,000	0.01%
206	ЦЭВЭЭНЖАВ ОТГОНХОРЛОО	1,180	118,000	0.01%
207	АДЪЯА АЛТАНГЭРЭЛ	1,180	118,000	0.01%
208	ДАМДИНСЭРЭЭНЭН МӨНГӨНЧИМЭГ	1,160	116,000	0.01%
209	ДОЛГОРСҮРЭН ЧИМЭГБАЯР	1,120	112,000	0.01%
210	ГОМБО АНДРЕЙ	1,120	112,000	0.01%
211	МӨНХ-ОЧИР МӨНГӨН САР	1,120	112,000	0.01%
212	ООРОЙ ЭНХТАЙВАН	1,110	111,000	0.01%
213	БАРИУЛ БИЛЭГСАЙХАН	1,100	110,000	0.01%
214	ЦЭДЭНДОРЖ ЭРДЭНЭБАТ	1,030	103,000	0.01%
215	ГУНАНБАЙ ПҮРЭВДОРЖ	1,020	102,000	0.01%
216	БАТХУЯГ МӨНХЗҮЛ	1,010	101,000	0.01%
217	НОРЖИНЧУЛУУН УНДАРМАА	980	98,000	0.01%
218	БУЯДАА БАТЦЭНГЭЛ	980	98,000	0.01%
219	ӨЛЗИЙОРШИХ ОДБААТАР	960	96,000	0.01%
220	ОЮУНБАТ СОЛОНГО	950	95,000	0.01%
221	ЖАМСРАНЖАВ БАЙГАЛМАА	950	95,000	0.01%

Хувьцаа эзэмшигчдийн
2015 оны ...дугаар сарын-ний өдрийн
..... тоот тогтоолоор батлав

222	ЗОРИГОО ЗОЛЗАЯА	930	93,000	0.01%
223	СОСОР САНЖААЖАМЦ	920	92,000	0.01%
224	БАТЧУЛУУН ПЭРЭНЛЭЙМАА	910	91,000	0.01%
225	САМПЛ БАЯРЖАРГАЛ	850	85,000	0.00%
226	МИЖИД ГЭРЭЛМАА	820	82,000	0.00%
227	ЭРХЭМБААТАР ОТГОНЦЭЦЭГ	800	80,000	0.00%
228	ЁНДОНЖАМЦ ДААРИЙМАА	770	77,000	0.00%
229	ГАНБОЛД ТУЯА	760	76,000	0.00%
230	БЯСГАЛАН ЭНЭРЭЛ	760	76,000	0.00%
231	НЯМДОРЖ НАРАНТУЯА	750	75,000	0.00%
232	БААТАРСАЙХАН БАТЗОРИГТ	750	75,000	0.00%
233	МЯГМАР ИЧИННОРОВ	750	75,000	0.00%
234	ДОВДОННЯМ БАЯРТУНГАЛАГ	740	74,000	0.00%
235	ЦЭДЭВДОРЖ НЭРГҮЙ	740	74,000	0.00%
236	БАЯРЖАРГАЛ ОЮУН-ЭРДЭНЭ	740	74,000	0.00%
237	ДАШДЭНДЭВ ШАГЖ	730	73,000	0.00%
238	ЭНЭБИШ БАТЗОРИГ	720	72,000	0.00%
239	ГАНХУЯГ САРАНЦЭЦЭГ	720	72,000	0.00%
240	САНЖМЯТАВ САНЖХҮҮ	700	70,000	0.00%
241	БАЯНЦАГААН ГАНХУЯГ	700	70,000	0.00%
242	САМБАЛХҮНДЭВ САЙНБАЯР	700	70,000	0.00%
243	ВААНЧИГ БҮЖИНЛХАМ	700	70,000	0.00%
244	ГАЛДАН ОДОНГЭРЭЛ	690	69,000	0.00%
245	ОСОР ДАВААСҮРЭН	680	68,000	0.00%
246	БАТНАСАН БАТЧИМЭГ	680	68,000	0.00%
247	МАНДАЛСҮРЭН ДАВААБАЯР	680	68,000	0.00%
248	САРАНХҮҮ МАНДУХАЙ	670	67,000	0.00%
249	МӨНХӨӨ ОТГОНБАЯР	670	67,000	0.00%
250	МЯГМАР НАНДИНЦЭЦЭГ	670	67,000	0.00%
251	БУЛТТАВАНЖИН БАЯРМАГНАЙ	670	67,000	0.00%
252	ДАРЬГЕРБЕК УЛАРА	650	65,000	0.00%
253	БААТАР ОЮУНБАТ	640	64,000	0.00%
254	ЦЭНД-АЮУШ АЯНГА	630	63,000	0.00%
255	ГОНЧИГЖАМЦ БҮЯННЭМЭХ	620	62,000	0.00%
256	БАДАМХАНД ТҮВШИНЖАРГАЙ	620	62,000	0.00%
257	БАТНАСАН ТУЯА	620	62,000	0.00%
258	ДАШНЯМ ХАНДЖАВ	610	61,000	0.00%
259	ГЭНДЭН ГАНБААТАР	580	58,000	0.00%
260	РАВДАН АЛИМАА	580	58,000	0.00%
261	ДАМБА УУГАНБААТАР	570	57,000	0.00%
262	ДОРЖСЭМБЭ БАТЗАЯА	540	54,000	0.00%
263	БАДАРЧ УРАНБИЛЭГ	540	54,000	0.00%
264	САНЖААЖАМЦ МӨНХБАЯР	530	53,000	0.00%
265	ОЧИРПҮРЭВ МӨНХНАРАН	530	53,000	0.00%
266	МАГСАР СЭЛЭНГЭ	530	53,000	0.00%
267	ДОРЖТОВУУ БАТЗАЯА	520	52,000	0.00%
268	БАДАМДОРЖ ТҮМЭНЖАРГАЛ	510	51,000	0.00%
269	ИДЭЭ НАРАНТУЯА	510	51,000	0.00%
270	СҮХБААТАР БАТБАЯР	510	51,000	0.00%
271	ЧИМЭДЦЭРЭН ЭРДЭНЭЧИМЭГ	510	51,000	0.00%
272	ЧИМИДДОРЖ БУЛГАМАА	500	50,000	0.00%
273	БЯМБАА АМАРТҮВШИН	490	49,000	0.00%
274	ЖАРГАЛСАЙХАН ХАЛИУНСАЙХАН	490	49,000	0.00%
275	БАТЦООЖ АНХТУЯА	480	48,000	0.00%
276	ЭНХБААТАР ЭНХЗАЯА	480	48,000	0.00%
277	БЭХХУЯГ СОДГЭРЭЛ	460	46,000	0.00%
278	ГАЛБАДРАХ ХАЖИДМАА	460	46,000	0.00%

Хувьцаа эзэмшигчдийн
2015 оны ...дугаар сарын-ний өдрийн
..... тоот тогтоолоор батлав

279	ЭНХБАТ СҮНЖИДМАА	450	45,000	0.00%
280	ЭНЭБИШ МӨНХТУЛГА	440	44,000	0.00%
281	БААТАР БАТБОЛД	430	43,000	0.00%
282	БАТСҮХ ЗОЛЖАРГАЛ	420	42,000	0.00%
283	СОСОРБУРАМ НЭРГҮЙ	400	40,000	0.00%
284	ЗЭДБАЗАР ЗОРИГТ	390	39,000	0.00%
285	НАМЖИЛДОРЖ ЭРДЭМБИЛЭГ	370	37,000	0.00%
286	ОТГОНБААТАР САРАНТУЯА	350	35,000	0.00%
287	БЯМБАСҮРЭН МАРТ	350	35,000	0.00%
288	ӨЛЗИЙОРШИХ ОДБААТАР	340	34,000	0.00%
289	БААТАРЖАВ ГАНТУЛГА	340	34,000	0.00%
290	АЛТАНГЭРЭЛ БАТХИШИГ	330	33,000	0.00%
291	ОТГОНБИЛЭГ БИЛЭГСАЙХАН	320	32,000	0.00%
292	ОЮУНБИЛЭГ БАТТУЯА	310	31,000	0.00%
293	ДАВАА БАТЧУЛУУН	290	29,000	0.00%
294	НЯМАА ӨСӨХБАЯР	290	29,000	0.00%
295	ХҮРЭЛ НАРМАНДАХ	280	28,000	0.00%
296	НАЙДАН ТҮМЭНДЭЛГЭР	270	27,000	0.00%
297	АЛИХАН БАХЫБОЛ	250	25,000	0.00%
298	ДАШ ЦАГААНЧИМЭГ	240	24,000	0.00%
299	БАДАМДОРЖ УНДАРМАА	220	22,000	0.00%
300	АЮУШ ГАНБОЛД	102	10,200	0.00%
301	НАЦАГДОРЖ АРСЛАНБААТАР	70	7,000	0.00%
302	ДАМБАСҮРЭН БУДСҮРЭН	70	7,000	0.00%
303	ЭНХБОЛД МӨНХ-ЭРДЭНЭ	40	4,000	0.00%
304	БАДАМ БАТЦЭЦЭГ	30	3,000	0.00%
305	ДОРЖГОТОВ БАТДАВАА	10	1,000	0.00%
Эргэлтэнд байгаа хувьцаа		17,194,364	1,719,436,431	100.00%
Халаасны хувьцаа		1,602,164	160,216,393	
Шинээр гаргасан хувьцаа		1,765,059	176,505,900	
Нийт гаргасан хувьцаа		18,796,528	1,879,652,824	

Хэвлэсэн: 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр